

МОНГОЛ ДАХЬ ЗӨВЛӨЛТИЙН ЦЭРГИЙН ТҮҮХЭЭС ЦУХАС ӨГҮҮЛЭХҮЙ

Проф. Дашдоржийн Баярхүү¹

Монголд Зөвлөлтийн цэрэг орж ирж байрласан, буцсан, эргэж орж ирсэн, бүрмөсөн буцсан үйл явц бол 70 гаран жилийн урт түүхийг илтгэнэ. Тухайн цагтаа коммунист Монголын коммунист удирдагч байсан Ю.Цэдэнбалын тэмдэглэснээр, анх Лениний даалгавраар Зөвлөлтийн 5 дугаар арми анхлан 1921 онд орж ирсэн ба Нейманы командалсан Кубанийн 5 дугаар дивиз Баруун хойд Монголд байлдаж явжээ. Мөн партизан Щетинкиний отряд Хүрээг чөлөөлөх байлдаанд оролцож, тэндээс Рокоссовскийн морин бригад салж Шаамарт байрлаж үүрэг гүйцэтгэж байжээ. Улаан армийн ангиуд Монголд Цагаан гвардийн отрядуудыг сөнөөж дууссаны дараа 1925 онд Югзэрийн хийдийн дээд лам нарын бослогыг даралцсаны дараа нутагтаа буцжээ².

Ийнхүү буцах болсон нь үүргээ гүйцэтгээд буцаж гарсан бус Дундад Иргэн Улсын Засгийн газрын өмнө СССР-ийн Засгийн газрын хүлээсэн үүргийн дагуу буцсан хэрэг байв. Зөвлөлт-Хятадын хоорондын харилцааны үндсийг тодорхойлж 1924.05.31-нд Бээжинд байгуулсан түүхэн хэлэлцээрийн дагуу Улаан армийн ангиудыг Гадаад Монголоос гаргасан юм. Тэрхүү хэлэлцээрийн тухай 1924.10.18-нд СССР-ийн Төвийн гүйцэтгэх хорооны 2 дахь удаагийн сонгуулийн II чуулганд СССР-ийн Гадаад хэргийн сайд Г.В.Чичеринээс тавьсан илтгэлд:

1. Профессор Д.Баярхүү

2. Ю.Цэдэнбал. Би тангарагтаа үнэнч байсан, УБ, 1996, 76-78 дахь талд

- Монгол нь Хятадын бүрэн эрхийн дор оршиж байгааг хүлээн зөвшөөрч байна. Тэгэхдээ Монгол нь ДИУ-ын хил хязгаар доторхи бүрэн автономит, өөрийгөө эзэн мэдэх эрхтэйг бид ямагт мэдэгдэж байсан гэдгээ энд тэмдэглэх нь зүй. Үүнтэй холбоотойгоор Монголоос манай цэргийг гаргах тов, нөхцлийг дараагийн бага хурлаар тодорхойлох болно гэжээ.

1930-аад оны эхээр Зөвлөлтийн цэргийг Монгол руу илгээх асуудал Зөвлөлтийн эрх баригч Намын Төв Хорооны Улс төрийн Товчоон дээр яригдаж байжээ. Тухайлбал 1932 онд Монголд дэгдсэн бослого хүчрэгдэхгүй болж, Монголын ардын цэргийн зарим гарнизон босогчдын талд орсон тул Монгол руу 500 цэргээс бүрдсэн буриад-монголын морин цэргийн дивизион Улаанбаатарт шилжүүлэн байрлуулах, Троицкосавскт байгаа 750 хүний бүрэлдэхүүнтэй морин дивизионыг Монголд илгээх тухай гэсэн хоёр асуудлаар шийдвэр гаргаж өгөхийг хүссэн захидлыг Сочид амарч байсан И.В.Сталинд БХК(б)Н-ын Төв Хорооноос илгээснийг Сталин осолтой хэмээн үзэж, энэ нь СССР-ийн эсрэг Япон, Хятад, Монголын нэгдмэл фронт үүсэх бааз суурь болчихож магадгүй гэж сэрэмжлүүлсэн цахилгаан утсыг Молотов, Ворошилов, Каганович нарт хариу илгээж байжээ³. 1932.08.13-нд Москвад Коминтерний Гүйцэтгэх Хороо, Бүх холбоотын Коммунист (большевик) Намын Төв Хороонд БНМАУ-д дэгдсэн эсэргүү бослогын талаар хэлэлцэж Коминтерний элч Шалва Элиавагийн илтгэлийг сонсож Монголын ардын цэргийг бэхжүүлэх, зөвлөлтийн цэргийн ба дотоодыг хамгаалахын зөвлөх сургагч нарын ажлыг сайжруулахыг чухалчилж байжээ⁴.

Цэрэг оруулахыг хуульчилсан анхны эрх зүйн баримт бичиг нь 1936.03.12-нд Улаанбаатарт гарын үсэг зурсан БНМАУ–ЗСБНХУ-ын хоорондын харилцан туслалцах Протокол байсан ба 1924 оны Зөвлөлт-Хятадын хэлэлцээрээр Монголыг Хятадын нэг хэсэг хэмээн Зөвлөлт хүлээн зөвшөөрсөн ч Хятадын тэр хэсгийг нь ийнхүү бүрэн эрхт улс хэмээн үзэж Протокол байгуулсан. Чингэхдээ 1934.11.27-ны Монгол–Зөвлөлтийн аман хэлэлцээртээ (джентльменское соглашение) үндэслэн тэрхүү Протоколыг байгуулсан. *“Цэргийн халдлагын аюулаас*

3. Ч.Дашдаваа. Коминтерний элч Шалва Элиава, УБ, 2013,16-17 дахь талд

4. Мөн тэр номд, 126-135 дахь талд

урьдчилан сэргийлэх, цэргийн халдлагад сануулга өгөх”, “Туравдагч этгээдээс СССР ба БНМАУ-д халдсан тохиолдолд харилцан дэмжих бүх арга хэмжээг авах” (1-р зүйл) гэх мэт хэд хэдэн заалт нь Монголд Зөвлөлтийн цэргийг оруулж байх үндэслэл болжээ. Протоколын 2-р зүйлд: *цэргийн халдлагад өртсөн тохиолдолд бүх талын тусламж, түүний дотор цэргийн тусламж үзүүлэх үүрэг харилцан хүлээх*, 3-р зүйлд: *нөгөө этгээдийнхээ нутаг дэвсгэрт харилцан тохиролцон цэргээ оруулах тухай заажээ*⁵.

Протоколын дагуу 1937 онд Улаан армийн ангиуд Монголд орж ирж байрласан. Гэхдээ Монголыг хамгаалах гэдэг утгаар бус, “*Ажилчин тариачны улаан армийг хөгжүүлэх, шинэчлэн зохион байгуулах III 5 жилийн төлөвлөгөө (1938-42)*”-ний дагуу Өвөр Байгалийн цэргийн тойргийг дахин зохион байгуулах ажлын хүрээнд говь цөл-тал хээрийн нөхцөлд цэргээ сургуулилах зорилгоор мото-хуягт 7-р бригадаа (мотоброневая бригада) Замын-Үүдэд, 8-р бригадаа Баянтүмэнд, 9-р бригадаа Өндөрхаанд байрлуулжээ. 1939 оны 4-9-р сард Зөвлөлтийн армийн 1-р бүлэглэлийн харьяанд шинэчлэн бүрдүүлсэн 57-р онцгой корпус нь Халхын голын байлдаанд оролцсон. 1940 оны 7-р сард армийн 1-р бүлэглэлийн харьяанд 17-р хээрийн арми Монголд үлдсэн, 1941 оны намраас Өвөр Байгалийн цэргийн тойргийн мэдэлд шилжсэн. Хожим нь 17-р армийн халааг домогт 39-р арми⁶ авсан түүхтэй.

Энэхүү 39-р арми нь 1945-1992 онд Монголын түүхнээ нэрээ мөнхжүүлжээ. Анхлан 1942 онд Калинины фронтын бүрэлдэхүүнд байгуулж буудлагын 5 дивиз, буудлагын ба танкийн нижгээд бригадын хүчээр вермахтын эсрэг тулалдаанд оруулжээ. Энэ арми хэд хэдэн фронтын харьяалалд орж байлдсаар 1945 оны хавар Кенигсбергийн хавьд ялалтаа өндөрлөжээ.

1945.05.01-нд 39-р армийг резервийн арми болгож Монгол руу шилжүүлэн байрлуулах шийдвэр гарч, мөн оны 6-р сарын 20-нд Өвөр Байгалийн фронтын мэдэлд өгчээ. Энэ арми 1945 оны 8-р сард Тамсагбулагийн чиглэлээр БНМАУ-ын хил давж Хянган-Мүгдэний фронтоор японы цэргийг бут цохин давшсаар Чанчунь хот орж байлдаанаа дуусгасан.

5. Советско-Монгольские договоры, соглашения и протокол, Дипломатический словарь, Том III, Москва, 1986, 252 дахь талд

6. [mongol.su/wiki/Гарнизоны 39-й армии контингента советских войск в МНР](http://mongol.su/wiki/Гарнизоны_39-й_армии_контингента_советских_войск_в_МНР)

Дайны дараа 39-р армийг Монголоос гэдрэг татаж оронд нь Дотоодын цэргийн төмөр замын ангиуд орж ирж байрлан, тэдний хүчээр төмөр зам барих бүтээн байгуулалтын ажлууд хийгджээ⁷. “Власовчууд” гэж манайхны ярьдаг нь эд байсан аж.

Энхийн бүтээн байгуулалт өрнөлөө гээд Монгол-Зөвлөлтийн хооронд цэргийн хамтын ажиллагаа огт саараагүй. Тухайлбал “ЗСБНХУ-аас БНМАУ-д 1958 онд зэвсэглэл ба цэргийн техник хэрэглэл нийлүүлэх тухай Проткол (нууц)” гэдгийг байгуулан 1959, 1960, 1965 онд сунгасан ба 1964 онд тусад нь нууц хэлэлцээр (ЗСБНХУ-тай зэвсэг техникийн талаар байгуулсан нууц хэлэлцээр– 1964.09.21) байгуулсан байдаг.

1965 оны 12 дугаар сарын 1-нд МАХН-ын Төв Хорооны Улс төрийн Товчооны хурал болж тусгай “маш нууц” тогтоол батлан Ц.Дүгэрсүрэн, Н.Жагварал, С.Лувсан, Д.Майдар, Д.Моломжамц, Ж.Самбуу, Ю.Цэдэнбал, Б.Лхамсүрэн, Н.Лувсанравдан нар гарын үсгээ зуржээ⁸. Түүнээс үг үсэг гээлгүй байгаагаар нь эшлэе:

- Дорнодод байдал хурцадаж олон улсын хооронд түгшүүрт байдал улам хүчтэй болж байгааг харгалзан тус улсын батлан хамгаалалтыг улам зузаатгах нь зүйтэй гэж үзсүгэй. Үүний тул ЗХУ-ын Зэвсэгт хүчнээс зохих ангийг гаргаж тус улсын нутагт байрлуулан өөрийн зардлаар барьж байх тухай хүсэлтийг ЗХУКоммунист Намын Төв Хороо, Зөвлөлтийн Засгийн газарт тавих нь зүйтэй гэж үзсүгэй.

Тогтоолд гарын үсэг зурсан даруйд мөн тэр өдрөө МАХН-ын Төв Хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн дарга Ю.Цэдэнбалаас ЗХУКН-ын Төв Хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга Л.И.Брежнев, ЗСБНХУ-ын Сайд нарын Зөвлөлийн дарга А.Н.Косыгин нарт маш нууц захидал бичжээ. Түүнийг утгачилан буулгавал:

- Дорнодод олон улсын байдал хурцдаж байгааг харгалзан улс орныхоо батлан хамгаалах хүч чадлыг бэхжүүлэх арга хэмжээ авч байна.

7. Мөн тэнд

8. Улс төрийн Товчооны хурлын протокол, Маш нууц, 1965 он 12-р сарын 1 (Зохиогч Д.Баярхүүгийн хувийн архивт бий)

- Зөвлөлт Холбоот Улсын сэтгэл харамгүй тусламжаар Монголын ардын армийг орчин үеийн техник зэвсэглэлээр хангаж байна, армийн бие бүрэлдэхүүнийг зөвлөлтийн мэргэжилтнүүд сурган бэлтгэж байна, гэвч гэнэтийн халдан түрэмгийлэл үйлдэгдвэл эдгээр арга хэмжээ нь баталгаа болж чадахгүй хангалтгүй байна.
- Эдгээрийг харгалзан БНМАУ-ын батлан хамгаалах хүч чадлыг бэхжүүлэх зорилгын үүднээс ЗСБНХУ-ын Зэвсэгт хүчнээс цэрэг гаргаж Зөвлөлт Холбоот Улс өөрийн зардлаар Монголд байршуулан, тэр цэргээ орчин үеийн байлдааны хүчирхэг техник, зэвсэглэлээр хангаж, соёл-ахуй, аж ахуйн болон бусад зайлшгүй объектуудаар хангалт хийхийг хүсч байна.
- Цэрэг байрлуулах газрын тухай болон бусад тодорхой асуудлыг жич хэлэлцэе.
- Манай хүсэлтийг ЗХУКН-ын Төв Хороо, Зөвлөлт Засгийн газар ойлгон хүлээн авч нааштай шийдвэр гаргана гэдэгт хатуу итгэж байна гэжээ⁹.

Дээрхи хурал болон захидал илгээсэн нь Л.И.Брежнев тэргүүтэй ЗСБНХУ-ын нам-засгийн төлөөлөгчдийн айлчлалаас сар хагасын өмнө болж өнгөрсөн ба айлчлан ирсэн төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд ЗСБНХУ-ын Батлан хамгаалах яамны сайд Зөвлөлт Холбоот Улсын маршал Р.Я. Малиновский оролцсон нь анхаарал татахаар юм.

1966.01.15-нд Улаанбаатарт Ю.Цэдэнбал, Л.И.Брежнев нарын гарын үсэг зурсан *Найрамдал, хамтын ажиллагаа, харилцан туслалцах тухай Гэрээн-д социалист хамтын нөхөрлөлийн батлан хамгаалах хүч чадлыг хэлбэрэлтгүй бэхжүүлэх зорилттой уялдуулан хоёр этгээдийн батлан хамгаалах чадварыг хангахад харилцан туслалцах тухай чухал заалт орсон. Найрсаг уламжлал ба НҮБ-ын Дүрмийг мөрдлөг болгон хоёр этгээдийн аюулгүй байдал, тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хангах зорилгоор цэргийнхийг оролцуулан бүх талын зайлшгүй арга хэмжээг хамтран авах тухай мөн тэнд заажээ. Улс түмний энх тайван, аюулгүй байдлыг ханган бэхжүүлэх, зэвсгийг бүх нийтээр бүрэн хураах, колоничлолыг устгах, Азийн*

9. Орос хэл дээрхи 2 нүүр захидал (Зохиогч Д.Баярхүүгийн хувийн архивт бий)

улсуудын хооронд найрсаг харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэн бэхжүүлэхэд чиглэсэн бодлогыг СССР, БНМАУ хоёр тууштай явуулан, дэлхийн бөмбөрцөгийн энэ бүс нутагт империалист түрэмгийллийн аюулаас сэргийлж, тийм аюулыг арилгахын төлөө хамтран тэмцэнэ хэмээн дээрхи гэрээнд заажээ¹⁰. Энэ заалтууд нь 1960-аад оны II хагаст Зөвлөлтийн цэрэг Монголд дахин орж ирж байрлах эрх зүйн үндэс болжээ.

Монгол руу Зөвлөлтийн цэрэг шилжүүлэн авчрах явдлыг хөнгөвчилсөн хувь хүний учир шалтгааныг энд бас дурдах нь зөв. Юу гэвэл

1. Ю.Цэдэнбал нь Эрхүү хотод суралцаж байх үеэсээ цэргийн мэргэжилд дур сонирхолтой болсон ба хожмоо дарга болоод Зөвлөлтийн жанжнуудын дургалуудыг хуудасных нь захад тэмдэглэл хийж ахин дахин унших шиг тааламжтай ажилгүй болсон гэлцдэг. Ю.Цэдэнбалын сэтгэлийг соронзодсон Зөвлөлтийн цорын ганц байгууллага бол улаан арми байлаа.
2. Мөн өрсөлдөгч Д.Төмөр-Очир, Л.Цэнд, 1964 оны Лоохуузтаны бүлгийг илчлэн бутцохисон гашуун сургамж түүнд эргэлт буцалтгүй нэгийг бодогдуулсан ба Зөвлөлтийн цэрэг шилжүүлэн авчирснаараа иймэрхүү аюулаас өөрийгөө эгнэгт хамгаалж чадна гэх итгэл үнэмшилтэй болжээ. Иймд учир шалтгааны тайлбарыг дэлхийн геополитик, “Хүйтэн дайн”-аас эрж хайх хэрэггүй мэт.

1960-аад оны сүүлчээр Хятадын ардын чөлөөлөх армийн (ХАЧА) хүчирхэг умард бүлэглэл Монгол, Зөвлөлтийн хилийн орчим байрлах болж, түүндээ 44 дивиз (хээрийн армийн 33 дивиз, механикжуулсан 11 дивиз) бүхий ерөнхий цэргийн 9 армийг багтааж, 4300 танк, 10 000 их буу, пуужингаар зэвсэглэжээ. Үүний сацуу өрхийн цэргийн 30 явган дивизийг сургуулилаж, болзошгүй дайсан СССР-ийн эсрэг дайнд бэлтгэж байв. Үүний хариуд Зөвлөлтийн зэвсэгт хүчний Алс Дорнодын цэргийн тойрог (ДальВО), Өвөр Байгалийн цэргийн тойргийг болзошгүй дайнд сойв.

10. Советско-Монгольские договоры, соглашения и протокол, Дипломатический словарь, Том III, Москва, 1986, 253-254 дэх талд

Зөвлөлтийн зэвсэгт хүчний агаарын десантын цэргийн командлагч армийн генерал Василий Филиппович Маргелов үзүүлэх сургуульд уригдсан Зөвлөлтийн коммунист намын Төв Хорооны хэсэг нөхөдтэй ярилцсан баримтыг хожим сөхжээ. Өөрт нь Хятадаар оролдохыг зөвшөөрөхгүй байна хэмээн тэрээр гомдоллож, өөрийнх нь “десантын багачууд”-ыг Бээжин дээр буулгачихвал зүгээрсэн, тэгэх юм бол тэд тэнд учрыг олно¹¹ хэмээн ярьж байжээ. Үүнээс үзвэл лав зөвлөлтийн төрлийн цэрэгт Хятад руу довтлох, бүр нийслэлийг нь эзлэн авах төлөвлөгөө байсан мэт.

1967 оны зунаас Алс Дорнодын ба Өвөр Байгалийн цэргийн тойргийг дахин бүлэглэж Балти орчмын цэргийн тойрог, Ленинградын цэргийн тойргоос танкийн ба мотобуудлагын дивизүүдийг татаж эхэлжээ. Энэ ажлын хүрээнд мөнөөх 39-р армийн түрүүч болгож хоёр дивиз бүхий армийн нэг корпусыг Монголд эхлэн байрлуулсан ба зөвлөлтийн барилгын ба төмөр замын цэргийн ангиуд Монголын бүтээн байгуулалтын ажилд оролцож байв¹².

1970 оны эх гэхэд 39-р арми Монгол руу шилжин байрлажээ. Ерөнхий цэргийн эл арми нь 7 нэгтгэлээс бүрдэх ба нэгтгэл бүр нь 330 хүртэл танк бүхий хүчирхэг цохилтын бүлэг болж Хятадын хилд ойрхон байрлав. СССР-ийн БХЯ-наас гаргасан захирамжийн дагуу агаарын цэргийн 23-р армийн (штаб нь Чита хотод) цохилтын бөмбөгдөгч, сөнөөгч-бөмбөгдөгч 20 хороог Монгол руу шилжүүлэн байрлуулахдаа “Өвөр Байгалийн зэрлэг хээр тал”-д нислэг хийх, өнгөлөн далдлахад саадгүй гэж үзжээ. СССР-ийн БХЯ-ны 1967.07.22-ны захирамжинд Монголын нутаг дэвсгэрийг “Өвөр Байгалийн зэрлэг хээр тал” хэмээн цээрлэлгүй нэрлэсэн байдаг¹³. “Өвөр Байгалийн зэрлэг хээр тал” дахь нисэх хүчний салбар штабыг 1968 онд Уланбаатарт нээж, хоёр хороо бүхий 29-р дивизээ байрлуулж эхэлжээ. 1971 он гэхэд Монголын арми өөртөө сөнөөгч нисэх онгоцны хороотой болж, түүнийг хамтарсан хороо болгов. Мааньт, Чойрт зөвлөлтийн агаарын цэргийн 104, 126-р хороод байнга сургуулилт хийх ба зарим мэдээгээр бол Чойрт агаарын цэргийн 46-р дивизийн штаб ажиллаж байснаас гадна Ми-4 и Ми-6

11. Леонид Млечин. Брежнев, NEPKO publishing, Улаанбаатар, 2013, 441 дэх талд

12. Советские войска в Монголии, legendtour.ru/rus/mongolia/

13. Последние бронепоезда Советской Армии, ru.wikipedia.org/wiki/Советские_войска_в_Монголии

нисдэг тэргээр зэвсэглэсэн 68-р хороо Налайх хавьд байрлаж байв. Нисдэг тэрэгний тусгай хороог Зөвлөлтийн баруун хэсгийн Калинов, Овруч, Броды, Житомир хотуудаас татаж байрлуулжээ¹⁴. Хичнээн нисдэг тэрэг хаана хаана байрлаж байсныг тооцоолох аргагүй, нисдэг тэрэгний жижиг эскадриль, отряд хааяагүй байсан гэдэг. Нисэх хүчний ар талын хангалт үйлчилгээний, хамгаалалтын, радиотехникийн, холбооны, удирдлагын анги салбар, агуулах, полигон тоймгүй олон. Эдгээрт үйлчилдэг 6 том аэродром байсан гэхээс өөрөөр тоо гаргах аргагүй.

1970-аад оны дунд үе гэхэд Монголд зөвлөлтийн 85 мянган цэрэг, 10 мянган цэргийн сургагч, цэргийн мэргэжилтэн орж ирж байрлаад байв¹⁵. Ерөнхий цэргийн 39-р армийн штаб нь БНМАУ-ын БХЯ, Жанжин штабаас нэг км хүрэхгүй газар байрлаж, бүрэхдэхүүндээ танкийн 2 дивиз (нижгээд 330 танк, 11 мянган цэрэгтэй), мотобуудлагын 3 дивиз (нижгээд 14-15 мянган цэрэгтэй), мөн тусдаа сургуулийн нэг дивиз, Чита-Монголын хооронд байнга ирэн очин байдаг нисэх хүчний нэг дивиз, зенит-пуужингийн 2 бригад, тагнуулын тусгай 2 бригад, радио техникийн бригад, төмөр замын бригад, тусгай хороодтой байлаа. Цэргийн стратегичдын тооцоолсноор, Монголын 7 хавтгай дөрвөлжин метр тутамд нэг цэрэг ногдохоор тэгж их цэрэгжүүлсэн байв. Энд Зөвлөлтийн цэргээс гадна тухайн үеийн БНМАУ-ын ардын арми, хилийн цэрэг, барилгын цэрэг, дотоодын цэргийг оруулж тооцоод тэгж үзсэн хэрэг болов уу.

1966 оны гэрээний дагуу Зөвлөлтийн цэргийн 2 дахь том хэсэг 1979 онд нэмэгдэж орж иржээ. Хятад-Вьетнамын дайны үеэр Украин, Белоруссаас нисэх хүчний хэд хэдэн хороодыг Монгол руу татаж ирсэн ба Хятадын ар шилэн дээр (хойд хил дагуу) цэргийн сүрийг үзүүлэх замаар энх тайван, шударга ёсыг сэргээн тогтоох амаргүй үүргийг өөртөө хүлээсэн байдаг. ЗХУКН-ын Төв Хорооноос гаргасан шийдвэрийн дагуу 1979 оны 3-р сарын 12-26-нд хоёр 7 хоногийн турш хил орчмын цэргийн тойргууд, Монгол дахь ерөнхий цэргийн арми, Номхон далайн флотыг дайчлан тийнхүү сүрийг үзүүлэх цэргийн хээрийн ба далайн сургууль хийжээ. Нийт 20 гаруй дивизийг Хятадын

14. Спецназ.орг – сообщество ветеранов спецназа России, СНГ и бывшего СССР (с) 2012г

15. mongol.su/wiki/Гарнизоны 39-й армии контингента советских войск в МНР

хойд хилийн орчимд тоглолтод оролцуулсан ба чингэхдээ 200 мянган цэрэг, 2600 танк, 900 нисэх онгоцыг хөдөлгөж, далайд байлдааны 80 хөлөг онгоцыг гаргажээ¹⁶.

Үүнд Монголын тал хээр, говьд явагдсан сургуулилт анхаарал татна. Монголын армиас гадна зөвлөлтийн армийн 6 дивиз оролцсоноос гурав нь эргэж нутаг буцалгүй Монголд үлджээ. Монголын нутагт хоёр бригад, агаарын гурван дивиз орж ирээд эргээд гарсан байдаг. Сибириэс Монгол руу 2000 км маршилсан дайчилгааны хээрийн сургууль хамтдаа явагдаж төмөр зам, агаарын зам, хуурай замын бүх гарцыг ашиглажээ. Хятадын хилийн районуудад контрудар өгөх, контратак хийх цэргийн тактикийг тэр үед боловсруулсан цэргийн урлагийн гайхамшигт тоглолт болсон хэмээн 1979 оны тэр үйл явдлыг цэргийн түүхчид дүгнэдэг¹⁷.

1966 оны Найрамдал, хамтын ажиллагаа, харилцан туслалцах тухай Гэрээний дараа байгуулсан хэд хэдэн эрх зүйн акт байна. БНМАУ-ын иргэний хамгаалалтыг бэхжүүлэхэд тусламж үзүүлэх тухай Засгийн газар хоорондын нууц хэлэлцээр (1969 он), Цэргийн техникийн нэгдсэн засварын газар байгуулах тухай нууц солилцох бичиг (1971 он), БНМАУ-д тусгай объект байгуулахад буцалтгүй тусламж үзүүлэх тухай Засгийн газар хоорондын нууц хэлэлцээр, БНМАУ-ын нутаг дэвсгэр дээр ураны орд газрыг ашиглах тухай нууц хэлэлцээр (1981 он) гэх мэтийг дурдаж болно.

1988 оны байдлаар ерөнхий цэргийн 39-р армид танкийн хоёр дивиз, мото-буудлагын гурван дивиз, тагнуулын нэг бригад, зенит-пуужингийн хоёр бригад, радиотехникийн нэг бригад, холбооны тусгай нэг хороо, инженерийн хоёр хороо, десантын дайрагч нэг батальон, нисдэг тэрэгний нэг хороо, радио тусгай батальон гэхчлэн үлдсэн байсан ба Дээд ерөнхий командлагч М.С.Горбачевын тушаалаар Зөвлөлтийн цэргийг Монголын нутаг дэвсгэрээс гаргах шийдвэр гараад байлаа. СССР-ийн туслалцаагүйгээр БНМАУ нь бүрэн эрхт байдлаа дангаар хангаж чадахгүй гэсэн Монголын Засгийн газрын удаа дараагийн мэдэгдлийг Дээд ерөнхий командлагч М.С.Горбачев үл хэрэгсэв.

16. В боях за Поднебесную. Русский след в Китае, coollib.com/b/279261/read

17. Мөн тэнд

Хил дээрхи цэргийн тоог хорогдуулах тухай Зөвлөлт-Хятадын хэлэлцээр 1989.02.04-д байгуулагджээ. Энэ хэлэлцээрийн дагуу Зөвлөлтийн цэрэг нутаг буцсан үйл явц Монголд өрнөв. Цэрэг буцах үйл ажиллагаа 28 сарын турш явагдсан.

1989.05.15-нд Монгол дахь 39-р армийг хэсэгчлэн гаргах (Багануур дахь мотобуудлагын 12-р дивизээ Улаан-Үд рүү татах гэх мэт тодорхой заалттай) тухай мэдэгдлийг Зөвлөлтийн талаас хийсэн. Танкийн хоёр, мотобуудлагын гурван дивизийг гаргах ба нийт 50 мянган цэрэг, 1816 танк, 2531 хуягт, 1461 их буу, байлдааны 190 нисэх онгоц, 130 нисдэг тэргийг гаргана, 1992 оны намар гэхэд энэ ажлыг дуусгана гэж заажээ¹⁸.

1989.04.03-ны өдрийн МАХН-ын Төв Хорооны Улс төрийн Товчооны тогтоол архивт бий. Утга нь: БНМАУ-ын нутагт түр байрлаж байгаа Зөвлөлтийн цэргийн нэлээд хэсгийг үдэн гаргахтай холбогдсон үзэл суртал-зохион байгуулалтын ажлыг Монголын талаас хариуцах хэсгийг байгуулах тухай. Монголын хэсгийн ахлагчаар тэр үеийн МАХН-ын Төв Хорооны Улс төрийн Товчооны гишүүн, Төв Хорооны нарийн бичгийн дарга, БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн орлогч дарга Ц.Намсрай, гишүүдэд П.Жасрай, Л.Моломжамц, Ч.Түмэндэлгэр, Г.Эрдэнэ, Ж.Ёндон, Ц.Гомбосүрэн, А.Жамсранжав, Л.Зантав, С.Ванчиндорж, Ш.Жадамбаа гэжээ¹⁹.

Зөвлөлтийн ГЯЯ-ны орлогч сайд И.Рогачев 1989 онд Улаанбаатарт ирээд байхдаа нэгэн сонин баримтыг дэлгэсэн. Зөвлөлтийн цэргийг Монголоос гаргах тухай анхны яриа хэлэлцээ 1986 онд ЗСБНХУ-ын перестройкийн үед Монгол-Зөвлөлтийн хооронд явагджээ. Санал солилцох хэмжээнд байсан энэ тохиролцоо 1987 онд хэрэгжиж, цэргийн эхний хэсгийг эх оронд нь буцаажээ. МАХН-ын Төв Хорооны Эрх зүйн бодлогын хэлтсийн эрхлэгч Л.Моломжамц дараахан нь энэ тухай анхлан нийтэд ил болгосон байх бөгөөд 1987 онд МАХН-ын Төв Хорооны Улс төрийн Товчооны гишүүн, Сайд нарын Зөвлөлийн орлогч дарга С.Лувсангомбо тэргүүтэй тусгай комисс ах нарыг үдэж мордуулах ажлыг хариуцжээ. 1987 онд үлдээсэн цэргийн хотхонууд манайд цэргийн зориулалтаар ашиглагджээ²⁰.

18. ТАСС-ын мэдээ, 1989.10.28

19. Л.Моломжамц. Улс орны эдийн засгийн ашиг сонирхолд үндэслэн, “Цаг үе” 1989.05.20 № 14 (122), 3-5 дахь талд

20. Игорь Рогачевын ярьсан нь, “Цаг үе” 1989.11.10 № 31 (139), 7 дахь талд

1989.05.15-аар Зөвлөлтийн цэргийг гаргах ажлын үргэлжлэл болох 2 дахь томхон хэсэг гарсан байна. 1989 оноос Зөвлөлтийн цэргийг үе шаттай гаргах график хэрэгжсэн. Эхний ээлжинд танкийн хоёр дивиз, нисэх хүчний нэг дивиз гарч, агаарын довтолгооноос эсэргүүцэн хамгаалах ба бусад ангиуд үлдэнэ гэсэн байна. Жишээ нь танкийн нэг дивизийг гаргах ажил 1989.05.15-07.28-ны дотор үргэлжилж бөөн нүүдэл суудал болж байжээ.

Тэр зундаа томхон 4 цэргийн хотхон суларсан нь Орхон, Шивээговь, Мандалговь, Мааньт ба Улсын Төлөвлөгөөний Комиссын дарга П.Жасрай гарнизонуудыг шилжүүлж ашиглалтад хүлээн авчээ. Орхоны танкийн дивизийн хөвөрсөн цуваа Эрдэнэтээс галт тэргэнд шилжиж өдөрт 2 цуваа үдэж байсан тул вокзал дээр найрамдлын цуглаан тасрахгүй, Улаанбаатар, Эрдэнэт, Булган, Дорноговьд Зөвлөлтийн дайчдыг үдэж мордуулахтай холбогдсон уулзалт, үдэшлэг, цуглаан, сурталчилгаа зохиогдож, бүхэлд нь энэ ёслолыг Төв Хорооноос Ц.Намсрай дарга биечлэн хариуцав.

Булган дахь Зөвлөлтийн цэргийн суларсан хотхонд (10 мянган хүн ам суурьшихаар төлөвлөсөн) нийслэлээс Соёлын дунд сургууль, Цэцэрлэгийн багшийн сургууль, Булганаас ХАА-н ТМС, Барилгын ТМС, Хялгантын Ойн ТМС шилжиж байрлана гэсэн тэр үеийн дайчин төлөвлөгөө хэрэгжсэн эсэх нь бүү мэд. Шивээговийг бүхэлд нь тэр үеийн Эрчим хүч, геологи, уул уурхайн яам шилжүүлэн авсан бөгөөд Налайхын уурхайг Шивээговь руу шилжүүлнэ гэсэн шийдвэр гарсан. Орхоны амралт гэж одоо байгаа эсэхийг мэдэхгүй. Орхон, Сүмбэрт МҮЭ-ийн Төв Зөвлөлийн харьяа амралт нээгдэнэ гэсэн шийдвэр байв. Мөн Орхоны дивизийн суларсан хотхонд нийтийн аж ахуйн ТМС, аж үйлдвэрийн ТМС байрлуулахаар заасан. Мааньтад 60 000 кубметрийн шатахууны агуулах суларна, Чойрын гарнизоныг Сүмбэрийн сангийн аж ахуй болон Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллага, Геологи хайгуулын экспедицэд шилжүүлнэ гэхчлэн жагсаасан байв.

Тухайн үед БНМАУ-д түр байрлаж байсан Зөвлөлтийн цэргийн командлагч хошууч генерал Л.С.Майоров 1989 оны 10 дугаар сард хэвлэлийн бага хурал хийлгэж, чухам юуг Монголын талд хүлээлгэн өгснөө дурдсан юм. Цэрэг гаргах эхний үе шат нь 1989 оны тавдугаар сараас наймдугаар сард сард хэрэгжиж, төлөвлөгөө ёсоор 37 цэргийн

хотхон хүлээлгэн өгөх байсан ч 52 гарнизон хотхон хүлээлгэн өгчээ. Орон сууцны 92 барилга шилжүүлэхээс 123-ыг, 913 өрөөтэй нийтийн 13 байр, 10 000 хүний хооллох 29 зоогийн газар, 6500 хүний суудалтай 20 клуб, 16 800 хүний багтаамж бүхий 109 казарм, 350 ортой 15 эмнэлэг, 15 дэлгүүр, ахуйн үйлчилгээний 3 төв, ерөнхий боловсролын 5 сургууль, талхны цехүүд, хими цэвэрлэгээний хэд хэдэн комбинат (өртөг нь тэр үеийнхээр 500 сая төгрөг) гэхчлэн асар их хөрөнгийг Монгол-Зөвлөлтийн хамтарсан комисс шалгаж үзээд хүлээлцжээ²¹.

Зохиогч би өөрөө 1980-1984 онд цэргийн албанд зүтгэж, арми цэргийн түүх гайгүй гадарладаг болсных дүгнэлтийг орлуулж хэлэх хэдэн онцлог мөрүүд байна:

- ХХ зуунд Монголын нутаг дэвсгэрт зөвлөлтийн цэрэг 1921, 1937, 1945, 1967 онд 4 удаа орж ирж байрласан байх ба Монгол орныг гаднын халдлагаас хамгаалах гэхээсээ илүүтэй оперативын багтаамж, оперативын орон зайгаас нь шалтгаалан буфер бүс, Оросын Сибирийг хамгаалах түшиц газар хэмээн үзэж цэргээ оруулж байсныг цэргийн урлагийн түүхчид өгүүлдэг.
- 1939 оны Халхын голын байлдааны үед Баянтүмэн, Матадыг СССР-ийн газар нутаг мэт үзэж, төмөр зам тавьж, цэргээ оруулсан гаргасан байдаг ба хожим “Дайсны цэргүүдээ сонсцгоо!” уран сайхны кино бүтээх үед манай талаас хүсэлт гаргаж чармайлт тавьж байж “БНМАУ-ын хил рүү орлоо” гэх хэсгийг оруулсан тухай цэргийн зарим түүхч өгүүлснийг энд дурдъя.
- Ерөнхийд ажваас “Бөөсийг танкаар няцалдаггүй” гэх зарчмаар Монголд хандаж байсан нь дээрхи баримтуудаас ажиглагдах шиг. Монголын чиглэл бол стратегийн хувьд огтын ашиггүй мухар газар. Сибирийн цөллөгөөс ч дор газар гэх үзэл хүчтэй байсан. Тиймдээ ч дайны хангалтын сүлжээндээ Монголыг төдийлөн ач холбогдолтой бүс нутаг хэмээн үздэггүй байсан болов уу.
- Монголын армийг хавсарга, ар талын хангалт үйлчилгээний салбар мэт үзэж 1939, 1945 оны дайнд оруулсан байдаг ба монголын цэрэгт байлдааны зураг, байлдааны журнал байхгүй

21. Л.С.Майоров. Зөвлөлтийн цэргийн эхний ээлж гарав, “Цаг үе” 1989.10.10 № 28 (136), 4 дэх талд

байсан зэрэг нь онцын ач холбогдол өгч, холбоотон хэмээн үздэггүй байсных болов уу.

- СССР-ийн хувьд Монголд оруулсан цэргээ “Группа войск” гэж үзэхгүйгээр Өвөр Байгалийн (ЗабВО) цэргийн тойргийнхоо бүрэлдэхүүнд шууд харьяалуулж байсан онцлогтой. Монголын оперативын багтаамж, оперативын орон зай сул учраас цэргийн стратегийн хувьд ашиггүй газар гэдгээс энэ нь үүдэлтэй. Гэтэл Зүүн Герман дахь цэргээ “Герман дахь цэргийн бүлэглэл”, Польш дахь цэргээ “Умард бүлэглэл”, Чехословак дахь цэргээ “Төвийн бүлэглэл”, Унгар дахь цэргээ “Өмнөд бүлэглэл” гэж нэрлэж онцгой ач холбогдол өгч байжээ.
- Оросын цэргийн стратегичид Монголыг элдвээр хардсаар ирсэн. Одоо ч хардлага үргэлжилж байна. Төв аймагт барьж байгуулж буй Хөшигтийн олон улсын нисэх онгоцны буудлыг японы хөрөнгөөр японоор халхавчлан бариулж буй НАТО, Америкийн нисэх хүчний нөөц буудал мэтээр, жил бүр явагддаг “Хааны эрэлд” олон улсын цэргийн хээрийн сургуулийг АНУ, НАТО-гийн цэргийн сургуулилт мэтээр, Оюу Толгой дахь хөрөнгө оруулалтыг НАТО-гийн гишүүн орнууд хөрөнгөө байршуулсан мэтээр хардах явдал байсан, байгаа. Тэгвэл 2015 оны Монгол Улсын гадаад бодлогод тунхаглаж буй төвийг сахих бодлого нь Оросын талын элдэв хардлагыг арилгах болов уу хэмээн найдна.

ХАВСРАЛТ

БНМАУ дахь Зөвлөлтийн ерөнхий цэргийн 39-р арми²²

Ерөнхий бүтэц	Танкийн 2 дивиз – нэг дивиз нь 330 танктай, 11 мянган цэрэгтэй	Мотобуудлагын 3 дивиз – нэг дивиз нь 14-15 мянган цэрэгтэй
	Сургуулийн нэг дивиз	Зенит-пуужингийн 2 бригад
	Тагнуулын тусгай 2 бригад	Радио техникийн бригад
	Армийн тийрэлтэт артиллерын хороо	Холбооны тусгай хороо
	Төмөр замын бригад	Инжерийн тусгай 2 хороо
	Десантын дайрагч батальон	Радио тагнуулын тусгай батальон
	Нисдэг тэрэгний тусгай хороо	Цэргийн 6 аэродром
Бие бүрэлдэхүүн	85 мянган цэрэг офицер +10 мянган цэргийн мэргэжилтэн зөвлөгч	
1992 онд гарч дууссан нь	50 гаруй мянган цэрэг, 1816 танк, 2531 хуягт, 1461 артиллер, 190 байлдааны нисэх онгоц, 130 нисдэг тэрэг	
Улаанбаатар дахь байршил ба бүтэц	Штаб Штабын хангалт-үйлчилгээний хороо Барилгын цэргийн ангиуд Төмөр замын цэргийн бригад Радио техникийн бригад Холбооны тусгай хороо Инжерийн тусгай 2 хороо Десантын дайрагч батальон Радио тагнуулын тусгай батальон	Налайх Нисдэг тэрэгний тусгай хороо Нисэх хүчний хамтарсан хороо Амгалан Холбооны цэргийн цахилгаан монтажийн батальон – Энэ батальон нь Монгол дахь зөвлөлтийн цэргийн бүх анги салбарт хүрч ажиллаж байсан. Улаанбаатарт тогтмол хоёр суман байрлаж, өөр хоёр суман нь Булган, Эрдэнэт, Багануур, Чойбалсан, Чойр, Мандал-Говь дахь тусгай объектод байрлаж байв

22. Д.Баярхүү. Зөвлөлтийн цэрэг орж ирсэн түүх, “Үндэстний тойм” № 18 (169) 2013.05.06

<p>Монгол дахь Зөвлөлтийн нисэх хүчин</p>	<p>Аэродром “Налайх” – 1969 онд ашиглалтад орсон Нисэх хүчний хамтарсан хороо (1971 оноос) Аэродром “Мааньт” – Баянхангай, Багахангай суурингийн ойролцоо Аэродром “Чойр” – Чойр хотоос 24 км-т, МИГ-23 онгоцны гол бааз Аэродром “Западный” – Зүүнбаянгийн ойролцоо Улаан-Уул сум</p>	<p>Аэродром “Сайн-Шанд” Аэродром “Чойбалсан” – 1968 -1990 онд байрлаж байсан. Тухайн үеийн хамгийн том аэродром. 2850 метр урт, 40 метр өргөнтэй, нөөцөндөө дахин 2500 метр урттай, 40 метрийн өргөнтэй, хатуу хучилттай.</p>
<p>Монгол дахь байришил ба бүтэц</p>	<p>Чойбалсан Анх 1954.01.25-нд Сайншандаас Зөвлөлтийн дотоодын цэргийн төмөр замын цэргийн хороог тийш нь шилжүүлэн байршуулсан. Энэ анги 1954–1974 онд ажилласан. 1969 онд Су-7 онгоцны, 1971 онд Су-17 онгоцны бааз байгуулж аэродром ашиглалтад оруулсан. Гвардийн танкийн 2-р дивиз /330 танктай, 11 мянган цэрэгтэй/ Тагнуулын тусгай 25-р бригад Баян-Уул сум Агаарын довтолгооноос эсэргүүцэн хамгаалах салбар</p>	<p>Чойр Мотобуудлагын 41-р дивиз /14-15 мянган цэрэгтэй/ Пуужингийн тусгай дивизион Танкийн хороо Сөнөөгч нисэх онгоцны хороо Сөнөөгч нисэх онгоцны автомат удирдлага бүхий тусгай батальон Нисэгчгүй тагнуулын онгоцны тусгай эскадриль Тусгай зориулалтын анги Засварын батальон Барилгын батальон Цэргийн госпиталь Сантехникийн батальон Авто тээврийн батальон</p>
<p>Булган Танкийн 51-р дивиз /330 танктай, 11 мянган цэрэгтэй/</p>	<p>Сайншанд Сайншандын гарнизоны түүх 1935 оноос эхэлсэн. Халх-Голын дайны үед Сайншанд дахь зэвсэг галт хэрэгсэлийн агуулахаас хангалт хийж байсан. “Жуковских” гэх нэртэй хуаранг тэр үед байгуулсан. 1970-аад онд Бээжингээс Европ руу нисч буй авиарейсыг хянах радиомаяк байрлуулсан. 1983–1991 онд агаар мандлын тандалтын пуужингийн станц ажиллуулж, М-100Б и ММР-06 хэмээх пуужингийн комплексоор дамжуулан атмосферын түвшинд тандалт хийж байсан. Агаар мандлын тандалтын пуужингийн станц Цэргийн гурван хотхон: “Умард” буюу “Найрамдал” хотхонд</p>	

Монгол дахь Зөвлөлтийн цэргийн түүхээс цухас өгүүлэхүй

<p>Монгол дахь байршил ба бүтэц</p>	<p>Булган Танкийн 51-р дивиз /330 танктай, 11 мянган цэрэгтэй/</p>	<p>Танкийн хороо Их бууны хороо Зенит-пуужингийн хороо Инженерийн хориглолтын бригад Инженерийн хориглолтын тусгай батальон Тусгай зориулалтын салбар Барилга-ашиглалтын суман Хээрийн ус хангамжийн тусгай батальон Холбооны батальон “Өмнөд” хотхонд Мотобуудлагын хороо Комендантын анги Эмнэлгийн батальон “Дорнод” хотхонд Цэргийн аэродром Агаарын цэргийн комендант Тусгай зориулалтын салбар</p>
	<p>Багануур Мотобуудлагын 12-р дивиз /14-15 мянган цэрэгтэй/</p>	<p>Дорноговь, Овоот–Хурал Радиотехникийн тагнуулын тусгай анги Зөвлөлтийн зэвсэгт хүчний жанжин штабын Тагнуулын ерөнхий газарт шууд захирагддаг “Горизонт” экспедицийн шууд харьяаны анги. Сонсох, чагнах, агаарын хайгуул хийх, пеленгац ажиллуулах замаар байнгын байлдааны жижүүрлэлт явуулна. Сайншанд, Арвайхээр, Мандалговь дахь радио тагнуулын ангиудтай хамтран ажиллана. Маш сайн өнгөлөн далдлагдсан. Хятадын сансрын Зюцзоань баазаас 200 км-ийн зайд орших тул хятадын дунд тусгалын баллистик пуужингийн туршилтыг байнга хянаж байсан.</p>
<p>Эрдэнэт Мотобуудлагын 149-р дивиз /14-15 мянган цэрэгтэй/</p>	<p>Дорноговь, Зүүнбаян Цэргийн аэродром</p>	
	<p>Мандалговь – Арвайхээр – Шивээ-Говь Тагнуулын тусгай 20-р бригад Бригадыг 1972 онд Батлан хамгаалахын сайдын тушаалаар байгуулсан.</p>	

PAX MONGOLICA

	<p>“Тусгай зориулалтын” гэсэн тодотголтой. Уул-говь цөлийн нөхцөлд ажиллах ийм бригад өмнө нь Зөвлөлтийн армид байгаагүй, 1988 онд бригадыг механикжсан бригад болгон өөрчилсөн. Бригадын байдааны даалгавар нь гол хүчний өмнө орж тактикийн тагнуул хийх, орон нутгийн чанартай тусгай-онцгой даалгавар биелүүлэх, Хятадын цөмийн зэвсгийн туршилтын Лобнуур дахь полигоныг эзлэн авч жагсаалаас гаргах, үүний тулд байнга өндөржүүлсэн бэлэн байдалд байна.</p>	<p>Дорноговь, Улаан-Уул сум Цэргийн аэродром</p>
	<p>Мандалговь Радио батальон</p>	<p>Эрхэт өртөө (УБ-Дарханы төмөр зам дагуу) Автозасварын батальон Их бууны сум, галт хэрэгслийн агуулах</p>
Стратегийн удирдлага	<p>Зөвлөлтийн Алс Дорнодын цэрэг</p>	<p>Лениний одонт Өвөрбайгалийн цэргийн тойрог</p>
Хоршиж ажиглах	<p>Улаан тугийн одонт Сибирийн цэргийн тойрог</p>	<p>Улаан тугийн одонт Алс Дорнодын цэргийн тойрог</p>
Болзошгүй дайсан	<p>1. ХАЧА-ийн Бээжингийн цэргийн тойрог Хэбэй, Шаньси, Өвөр Монголын мужийн 3 цэргийн тойрог, Бээжин, Тяньжины 2 гарнизон, цаашаа 24 салбар тойрог 2. ХАЧА-ийн Шэньяны цэргийн тойрог Хэйлунзян, Жилинь, Ляониний мужийн 3 цэргийн тойрог, салбар 17 тойрог, 18 гарнизон</p>	<p>3. ХАЧА-ийн Ланьжоугийн цэргийн тойрог 4. ХАЧА-ийн Урумчийн цэргийн тойрог</p>

Зохиогчийн энэхүү судалгааны өгүүлэл нь тус хүрээлэнгийн түүх судлаач-профессорын судалгааны өгүүлэл бөгөөд түүний ГХЯ-нд эрхэлж буй одоогийн албан тушаалтай огтоос хамааралгүй, өмнөх Элчин сайдынх нь байр суурь биш гэдгийг уншигчид тунгаах биз ээсэгтүүлийн зөвлөл.